

“ЭМ ЭН ДИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 30-ны өдөр

Дугаар:.....01/25

Улаанбаатар хот

“ЭМ ЭН ДИ”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Стадион оргил /17010/ Чингисийн өргөн чөлөө гудамж Кэй би тауэр 2 давхарт 203 тоотод 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдөр 11:00 цагт хийв.

Хурлын дарга Н.Ганчимэг: “ЭМ ЭН ДИ”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг тооллогын комиссын дарга Э.Ууганболд хурлын ирцийг талаар мэдээлэл өгнө үү.

Хурлын дэг:

Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах,

Компанийн ноогдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн гаргасан тогтоолын танилцуулах

ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

- Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт хариулт /хүн тус бүр 3 минут/
- Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах /3 мин/
- Санал хураалт явуулах /20 минут/
- Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /20 минут/
- Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах /5 минут/
- Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /5 минут/
- Хурлыг хаах
Та бүхэнд хэлэлцэх асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл тараасан материалд байгаа.

Хурлын ирцийн талаар тооллогын комиссын шийдвэр:

97360 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй буюу 83 хувьцаа эзэмшигч байгаагаас 67,265 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 67 % хувийг эзэмшигч 3 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна.

Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон компанийн дүрэмд заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од

Өнгөрсөн онд татварын мэргэшсэн зөвлөх болох ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК-тай хамтран ажиллаад үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын дүгнэлтээр баталгаажуулсан. НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн үйл ажиллагаагаа тохируулан баланс болон орлого, зарлага санхүүгийн жилийн татвар ноогдох тайлангаа Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккурэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор баталгаажуулан Сангийн яам болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ тус бүр хүргүүлэн ажиллаж байна.

Дэлгэрэнгүйг аудитын дүгнэлтээс үзнэ үү.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах,

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од

Компанийн үйл ажиллагаа нь Говь алтай аймгийн Тайшир суманд уул уурхайн операторын үйл ажиллагааг явуулж байгаатай холбоотойгоор дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг өөрчилөхөд гишүүд санал нэгтгэйгээр зөвшөөрөв.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

3. Компанийн ноогдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн гаргасан тогтоолын танилцуулах

ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэсний дагуу Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.5, 46.6 дах заалт болон ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн хурлын шийдвэрийг танилцуулж, санал нэгтгээгээр ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тогтоолыг танилцуулан гишүүд дэмжив.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

4. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах гишүүдийг сонгож байгаа болно. Гишүүдийг улираан сонгосонг доорхи байдлаар сонгогдсон байна.

Н.Отгон-Од

Пионг Чунг Фэх (Piong Choong Fah)

Чунг Чин Иенн (Chung Chee Yenn)

Н.Ганчимэг

Н.Гансүвд

Ц.Болд

Н.Ганбаатар

Б.Сарнай тус тус томилож бүрэн эрхийг сунгаж,

Лю Вен Тейк (Lew Wen Teik) бүрэн эрхийг дуусгавар болгож, Б.Сүнчигмааг сонгож бүрэн эрхийг сунгав.

Мөн ТУЗ-ийн даргаар Намсрайн Ганчимэг-ийг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Батсүхийн Эрдэнэтуяа нарыг үргэлжлүүлэн ажиллахаар тогтож гишүүд дэмжив.

5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоолын дагуу баталахыг зөвшөөрөв.

Хурлын шийдвэр:

Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хангалттай гэж үзэж хувьцаа эзэмшигчдийн 67%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах, Говь алтай аймгийн Тайшир суманд уул уурхайн операторын үйл ажиллагааг эрхэлж байгаа болно. Ингээд компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолоор баталгаажуулж, Компанийн дүрэм гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрч, Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх, компанийн бүртгэлтэй хаягийг хуулийн этгээтэд улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ дүрэмд өөрчлөлт оруулахыг 67%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
3. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй байх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн 67%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн эрхийг кумулятив аргаар сонгож сунгахыг хувьцаа эзэмшигчдийн 67%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар үргэлжлүүлэн доорх байдлаар томиллоо.

Үүнд:

“ЭМ ЭН ДИ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдээр:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Piong Choong Fah	67,265	67%
2	Chung Chee Yenn	67,265	67%
3	Б.Сүнчигмаа	67,265	67%
4	Н.Отгон-Од	67,265	67%
5	Н.Ганчимэг	67,265	67%
6	Н.Гансүлд	67,265	67%

“ЭМ ЭН ДИ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Ц.Болд	67,265	67%
2	Н.Ганбаатар	67,265	67%
3	Б.Сарнай	67,265	67%

5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг хавсралтаар танилцаж гишүүд санал нэгтгээгээр дэмжиж тогтоолоор нэр дэвшүүлэх, аудитын хороо, цалин урамшуулалын хорооны гишүүдийг сонгож хавсралтаар баталсугай.

Хурал 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 18 цаг 00 минутанд дуусав.

БАТАЛСАН:
Хурлын дарга:



Н.ГАНЧИМЭГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Нарийн бичгийн дарга:

Б.ЭРДЭНЭТУЯА